



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

Г

Г

Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож,
тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан “2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо” болон тус хорооноос 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зарласан “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт АрР-Орон нутаг 2024/02”-ийн үнэлгээний ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус хорооноос зарласан Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох АрР-Орон нутаг 2024/02 тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Эх элгэн нутаг ХХК-ийг шалгарсанд тооцсугай.
2. Сонгон шалгаруулалтад шалгарсан Эх элгэн нутаг ХХК-д Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” болон Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт 87.9 МГц-ийн “Радио давтамж, радио давтамжийн зурvas ашиглах” тусгай зөвшөөрлийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс 2029 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.
3. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
4. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

А.ЛУВСАН-ОЧИР

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР